



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 21,000,000.00 (хорин нэгэн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацааг дахин сунгаж, үнийг 10,000,000.00 (арван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Н.Бадрахцог нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002194

22-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ,
СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ашиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)
1	Тоёота лексус-570-J200, 70-02 УБҮ, JTJHY7AX0A4034320	2010/2013	21,000,000.00	21,000,000.00	-	2	10,000,000.00
	НИЙТ ДҮН		21,000,000.00 (хорин нэгэн сая)	21,000,000.00 (хорин нэгэн сая)			10,000,000.00 (арван сая)